



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Г

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Галын аюулгүй байдлын журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж, сэргээн засах төвийн эмч, ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Захиргаа аж ахуйн тасгийн эрхлэгч /О. Цэрэндаш/-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмчилгээний тасгийн эрхлэгч /Л. Эрдэнэбулаг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш. САРУУЛТУЯА



Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн
даргын 2021 оны 10 дугаар сарын
01... өдрийн 09 тоот тушаалын хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

9020010853.н. 9123733

1.1. Галын аюулгүй байдлын журамын гол зорилго нь НХСЗЭҮТэвий чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны гол бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчид, зочид, ажилчид болон барилга байгууламжийг манай улсын галын аюулгүй байдлын холбогдох хууль тогтоомж, дүрэмд нийцүүлэн галын аюул болон түүний үр дагавараас хамгаалахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын төлөвлөгөө нь Эмчилгээний тасаг, Захиргаа аж ахуйн тасаг болон бусад бүх ажилчидын хамтын ажиллагаанд үндэслэн хэрэгжинэ.

1.3. Хөтөлбөр нь галын сургалт, галаас сэргийлэх үйл ажиллагаа, гал түймрийн бэлэн байдал, галын үед авах арга хэмжээ зэрэг үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

ХОЁР. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан нь дараах үүрэгтэй

2.1.1. Галын Аюулгүй Байдлын хөтөлбөрийг боловсруулах, галын сургуулилтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, алдаа дутагдлыг залруулах болон хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт хийх

2.1.2. Барилгын болон бусад аюулгүй байдлын дүрэм, журамд нийцүүлэн галын аюулгүй байдлын болон амь нас аврах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, тест хийн бэлэн байдлыг хангах

2.1.3. Галын аюулаас хамгаалах инженерийн байгууламж, техник хэрэгслийн зураг, баримт бичиг, бүртгэлийг хадгалах.

2.1.4. Сэргээн засах төвийн барилга, байгууламжид болон түүний ойролцоо барилга угсралтын болон засвар хийгдэх тохиолдолд галын эрсдэлийн үнэлгээ хийх.

2.1.5. Галын аюулгүй байдлын үзлэг шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулах.

2.1.6. Шинээр ажилд орж буй ажилчдад галын аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах.

2.2. Харуул, хамгаалалтын нэгж нь гал гарсан тохиолдолд гал унтраах 102 дугаарт болон өөрийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтанд мэдэгдэх үүрэгтэй. Мөн гал унтраах машин ирхэд замын орц гарцыг чөлөөтэй нэвтрэх боломжоор хангасан байх үүрэгтэй.

2.3. Няглан бодогч нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан галд тэсвэртэй эд, хэрэглэл, оп хөнжлийн даавуу, хөшиг, тавилга, хогийн хувин зэргийг худалдан авах үүрэгтэй.

2.4. Тасгийн эрхлэгч нар өөрийн тасаг, нэгжийн түвшинд галын аюулгүй байдлыг ханган ажиллах үүрэгтэй.

2.5. Ажилтан бүр нь өөрийн ажил, үүргээ гүйцэтгэхдээ галын аюулгүй байдлыг дээд хэмжээнд сахиж ажиллана.

2.6. ГУРАВ. ГАЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Галаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь галын аюулгүй байдлыг дэмжих сурталчилах, галын аюулгүй орчинг бий болгох үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд дараах үйл ажиллагаанууд хамаарна:

3.1 Сэргээн засах төвийн барилга байгууламжид гол/утааг мэдрэх болон унтраах системүүдийг суурилуулах, гол/галын утааг хязгаарлах хөшиг, хаалгуудыг байршуулах, галаас аюулгүй гарах коридор, шат, гарцыг холбогдох стандартын дагуу бий болгох.

3.2 Тамхи татахыг хориглох журмыг мөрдүүлэх (Тамхи татахыг хориглох журмаас харна уу).

3.3 Захиргаа аж ахуйн тасгийн эрхлэгч нь сэргээн засах төвийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг байнга шалгаж тухай бүр засаж сэлбэхийн зэрэгцээ өндөр эрсдэлтэй дараах хэсгүүдэд хуваарийн дагуу үзлэг шалгалтыг зохион байгуулна.

Үүнд: Бүх ажилчдад зориулсан галаас урьдчилан сэргийлэх удирдамж

- 3.1.1 Галын хаалга, гарцын хэсэг, галын дохиололын кноп, гол унтраагч зэргийг хааж таглахгүй, чөлөөтэй байлгах.
- 3.1.2 Цахилгаан утас, залгуурыг тогтмол шалгаж элэгдсэн, шалбарсан бол шинэчлэх
- 3.1.3 Ослын үеийн цахилгаан тэжээлээр хангах систем, тоног төхөөрөмжийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор тогтмол хяналт тавьж, бэлэн байдлыг хангаж ажиллах
- 3.1.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийг зааврын дагуу ашиглаж алдаа, эвдрэл гарвал мэдээлж засуулах.
- 3.1.5 Гол тогооны хоол үйлдвэрлэлийн хэсгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа болон гол тогооноос гарч буй хаягдал, бохир, ашиглагдсан тос, тос баригчийн бөглөрөл үүсэх зэргээс сэргийлж тогтмол хяналт тавьж ажиллах
- 3.1.6 Шатамхай зүйлсийг хөргөгчинд болон халаагуурын ойролцоо хадгалахгүй байх.
- 3.1.7 Шатамхай, идэмхий, тэсэрч дэлбэрэх бодис, материалыг Химиин болон шатамхай бодисын аюулгүй ажиллагааны болон MSDS-ийн журмын дагуу хадгалаж, хэрэглэх.
- 3.1.8 Сэргээн засах төвийн даавуун хэрэглэл хадгалах өрөөнүүд, угаалгын хэсэг, хог хаягдал түр хадгалах цэг, хүчилтөрөгч хадгалах өрөөнүүд зэрэг эрсдэл аюултай хэсгүүдийн аюулгүй байдлын хяналт тогтмол хийх
- 3.1.9 Тавилга, даавуу, багаж хэрэгслийг худалдан авахдаа холбогдох журмын дагуу шатамхай байдлын зэрэглэлийг харгалзах.

ДӨРӨВ. ГАЛЫН БЭЛЭН БАЙДАЛ

Галын бэлэн байдлын зорилго нь барилга байгууламж, болон нийт ажилчдын зүгээс гол гарсан тохиолдолд хурдан шуурхай зөв хариу арга хэмжээ авахад бэлтгэлтэй байх явдал юм. Галын бэлэн байдалд:

4.1. Барилгын төлөвлөлт, угсралт, бүтэц нь орон нутгийн хууль, дүрэм, журмын шаардлагад нийцэж байгаа талаар холбогдох эрх бүхий этгэдээр хянуулах.

4.2. Барилга байгууламжийн галын бэлэн байдлыг тухайн орон нутгийн дүрэм, журамд нийцүүлэн шалгах ба үүнд гол унтраагчийг шалгаж, цэнэглэх, мөн гол,

утааг мэдрэгч болон холбооны тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг тогтмол шалгах үйл ажиллагаанууд багтана.

4.3. Аврах зам, гарцын бүдүүвч, галын дохиоллын кноп, гал унтраагчуудыг байршуулах.

4.4. Хамгийн ойрын хородгох газрыг, Сэргээн засах төвийн удирдлага нь онцгой байдлын үед нэгдсэн цугларах цэгийг тодорхойлж ажилчдад энэ талаар мэдээлэх.

4.5. Барилгын засвар, угсралт явагдахаар бол тэр хэсгийн галын эрсдлийг үнэлж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авах.

4.6. Үзүүлэх сургалт зохион байгуулах.

4.7. Аврах зам, гарцыг шалгах

ТАВ. ГАЛЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Галын голомт дээр:

5.1.1. Галын голомт дээр байгаа хүн дараах удирдамжийг дагана:

- a) Хэрэв аюулгүй гэж үзвэл галын голомтоос хүмүүсийг гаргах.
- b) 102-рүү залгаж мэдээлэх эсхүл галын дохиоллыг идэвхижүүлэх
- c) Бүх хаалгыг хааж гал болон утааг тархахаас хязгаарлах.
- d) Аюулгүй гэж үзвэл галыг унтраах эсхүл аврах гарцаар гарах

5.1.2. Хородгох газар - хэвтээ чиглэлийн хородгох газраар 2 давхар хаалганы цаадах (аюулгүй хүрч болох) хэсгийг сонгож болно. Хэрэв хэвтээ чиглэлийн хородгох газар олдохгүй бол гал хүрээгүй доод давхар руу шилжих ба эсхүл аврах гарцаар барилгаас бүр гарна.

5.1.3. Галын УТАА нь маш аюултай гэдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс утаатай газар аль болох газар/шалны түвшинд байж утаа арилтал босож зогсохгүй байх.

5.2. Галын голомтоос холдсон үед:

5.2.1. Галын дохиолол идэвхжсэн эсхүл ажилтан 102 утсаар мэдээлсэн бол эмнэлгээр зарлаж хүмүүст мэдээлнэ.

5.2.2. Хэвтэн эмчлүүлэгчийн хэсэгт:

5.2.2.1. Галын аюулын талаар зарлан мэдээллэх дохиолол идэвхжсэн тохиолдолд хэвтэн эмчлүүлэгчийн тасгийн ажилтан нь тасгийн бүх хаалгыг хааж, нүүлгэн шилжүүлэг хийх эсэх талаархи дараагийн зааврыг иртэл хүлээнэ.

5.2.2.2. Нүүлгэн шилжүүлэх удирдамж ирсэн тохиолдолд өөрөө явах чадвартай үйлчлүүлэгчийг шилжих газар руу зааж өгч явуулах ба хэвтрийн үйлчлүүлэгчийг туслахаар ирсэн эмнэлгийн ажилтнуудад хуваарилж өгч явуулна. Босоо шилжүүлгийг хамгийн аюулгүй шатны хонгилоор хийнэ. Хамгийн сүүлийн үйлчлүүлэгч явсны дараа өрөө тасалгааг шалгаж дуусаад өөрөө явна.

5.2.3. Амбулаторийн хэсэгт:

5.2.3.1. Галын аюулын талаар зарлан мэдээлэлсэн тохиолдолд амбулаторийн хэсгийн ажилтан нь бүх хаалгыг хааж, хийх гэж буй ажилбараа зогсоон, нүүлгэн шилжүүлэг хийх эсэх

талаархи дараагийн зааврыг иртэл хүлээх ба нүүлгэн шилжүүлэхэд бэлдэнэ.

5.2.3.2. Нүүлгэн шилжүүлэх удирдамж ирсэн тохиолдолд үйлчлүүлэгчийг шилжих газар руу зааж өгч явуулах ба хамгийн сүүлийн үйлчлүүлэгч явсны дараа өрөө тасалгааг шалгаж дуусаад өөрөө явна.

5.2.4. Бусад – Үйлчилгээний бус хэсэгт:

5.2.4.1. Үйлчилгээний бус бусад бүх хэсэгт галын дохиолол идэвхижсэн даруйд бүх хүмүүс шууд барилгаас аврах гарцаар гарна (Цугларах цэгт).

5.2.4.2. Нүүлгэн шилжүүлэх удирдамж ирсэн тохиолдолд ажилтан нь цуглах цэгт очиж цуглана. Тухайн нэгжийн ахлах ажилтан нь Штабын гишүүнд тасгийн цугласан хүний тоог өгч тасагт хүн үлдсэн эсэхийг магадлана. Штабын гишүүдийн хуваарийн дагуу үйлчлүүлэгчийг нүүлгэн шилжүүлэхэд туслана.

5.2.5. Эмчилгээний тасгийн эрхлэг Хариуцлагатай жижүүр эсхүл Аюулгүй байдлын ажилтан нь галын явц байдлын талаар бүх алба, тасаг, нэгжид цаг тухайд нь мэдээлэл өгч нүүлгэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. Мөн:

- Шаардлагатай хэсэгт нэмэлт хүн томилох;
- Хэрэв шаардлагатай бол цагдаагийн газар болон эмнэлгийн бусад ажилчдаас тусlamж авах;
- Хүн томилж аврах зам, шат, гарцыг чөлөөлөх;
- Шаардлагатай бол үйлчлүүлэгчдийн нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах.

5.2.6. Сувилахуйн багын үүрэг

5.2.6.1. Галд өртсөн хэсгийн Ахлах сувилагч нь галын үед үзүүлэх сувилахуйн үйлчилгээг удирдан зохион байгуулна. Бусад сувилагч нар Ахлах сувилагч болон ЧАБ эрхэлсэн орлогч даргийн өгсөн удирдамжийн дагуу ажиллана.

5.2.6.2. Бусад сувилахуйн багийн гишүүд, эм, хэрэгслийн агуулах, ариутгалын тасгийн ажилтнууд болон бусад ажилтнууд өөрсдийн ажлын байрыг орхихгүй ба ахлах сувилагч болон ээлжийн ахлах сувилагчийн удирдамжийн дагуу ажиллахад бэлтгэлээ хангана.

5.2.6.3. Гал барилгын алслагдсан хэсэгт гарсан бол ажлын байрыг орхихгүй, үйлчлүүлэгчдийг нүүлгэн шилжүүлэхгүй зааварчилгааг хүлээнэ.

5.2.6.4. Гал гарсан хэсгийн Ахлах сувилагч нар ойр ойрхон эргэлтүүд хийж дараах зүйлсийг хянана. Үүнд:

- Аюулд өртөх эрсдэлтэй үйлчлүүлэгчийг өрөөнөөс нь аюулгүй хэсэг рүү шилжүүлэх;
- Бусадад аюул, эрсдэлийн талаар мэдээлэх
- Галыг хязгаарлахын тулд хаалгануудыг хаах, шаардлагатай бол хүчилтөрөгчийг унтраах
- Хэн нэгнийг утсан дээр байнга байлгаж зааварчилгааг авна.

- Хэвтээ нүүлгэн шилжүүлэх эсэхийг ахлах сувилагч шийднэ.
- Бүх өвчний түүх, эмчилгээний бүртгэлийг гал гарсан хэсгээс холдуулна.

5.2.7. Лаборатори

Гал гарсан тохиолдолд хэдийд хий болон цахилгаан багаж хэрэгслийг унтраах, хэдийд ажлын байрыг орхих талаар дотоод журамтай байх. Зааварчилгааг хүлээж ажлын байрандаа байна.

ЗУРГАА. ЭМНЭЛГИЙН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЯВЦ

6.1. Нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах

Сэргээн засах төвд гал гарсан хэсгээс нүүлгэн шилжүүлэх эсхүл сэргээн засах төвийг бүгдийн нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг доорх тушаалтнуудын нэг нь харилцан ярилцасны үндсэн дээр гаргана.

- Галын унтраах баг (гал команд)
- Сэргээн засах төвийн дарга
- Эмчилгээний тасгийн эрхлэгч
- Захиргаа аж ахуйн тасгийн эрхлэгч

6.2. Хэвтээ нүүлгэн шилжүүлэг

Хэвтэн эмчлүүлэгчийн хэсэпт нүүлгэн шилжүүлэлт хийхэд дараах зүйлсийг анхаарна:

Хэрэв боломжтой бол авран гарах бүдүүвчийг дагана:

6.2.1. Амбулаторийн үйлчлүүлэгчид, зочид, зарим туслалцаа шаардлагагүй ажилчдыг (ижил давхарт байгаа) хэвтээ байрлалаар давхар хаалганы гаднах хэсэгт нүүлгэн шилжүүлнэ. Шилжиж дууссаны дараа хаалгаа хаана.

6.2.2. Нүүлгэн шилжүүлэхдээ хамгийн амараас хамгийн хэцүү рүү эсхүл эхлээд амбулаторийн үйлчлүүлэгчээс сүүлд нь хүнд өвчтөн гэсэн дарааллаар шилжүүлнэ.

6.2.3. Томилогдсон хүн нь бүх өрөөг шалгаж нүүлгэн шилжүүлэх явцад хүн үлдсэн эсэхийг нягтлана.

6.3. Босоо нүүлгэн шилжүүлэг

6.3.1. Хэрэв хэвтээ байрлалд нүүлгэн шилжүүлэх боломжгүй тохиолдолд босоо байрлалаар нүүлгэн шилжүүлнэ. Шилжүүлэг хийх дараалал нь ижил байна.

6.3.2. Гал, утаа хамраагүй доод давхар руу нүүлгэн шилжүүлнэ, суурин болон 1 давхар бол шууд барилгаас гарна.

6.4. Нэгдсэн цугларалт

Бүх ажилтнууд Урд байрны талбайн хэсэг дээр цугларна.

ДОЛОО. ЗӨӨВРИЙН ГАЛ УНТРААХ ХЭРЭГСЭЛ

7.1. Гал унтраагчийг ашиглах

Зөөврийн гал унтраагчийг эмнэлгийн шаардлагатай бүх хэсгүүдэд байрлуулсан байна. Зөөврийн гал унтраагчийг зөвхөн жижиг, хязгаарлагдмал галын үед

ашиглана. Эхлээд 102-рүү залгаж галын дуудлага идэвхижүүлсний дараа гал унтраагчийг авч дарааллын дагуу хэрэглэнэ.

- Хамгаалалтын түгжээг сугална.
- Гал унтраагчийн хошууг галын суурь руу чиглүүлнэ
- Бариулыг атгана
- Шүүрдэх хөдөлгөөнөөр галыг шүршиж унтраана.

7.2. ХАБЭА-н комисс нь зөөврийн гал унтраагчийг сар бүр шалгаж, дүүргэлт хийлгэнэ. Мөн нөөцийг хянана.

Найм . СУРГАЛТ

Сэргээн засах төвийн бүх ажилтан нь галын аюулгүй байдлын сургалтанд хамрагдсан байх үүрэгтэй ба шинэ ажилтан нь чиглүүлэх сургалтаар галын аюулгүй байдлын мэдлэгийг авсан байна. Байгууллага нь жил бүр галын аюулгүй байдлын сургалт ба сургуулилтыг зохион байгуулж бүх ажилтнуудаа хамруулна.